

**5 ДУГААР САРЫН 4-НИЙ
ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗЭЛ САНАА,
ОРЧИН ҮЕИЙН ЗАЛУУЧУУД
(Хөдөлгөөний 70 жилийн ойд)**

Ч. Батцэцэг

Орос оронд мандсан аугаа их Октябрийн социалист хувьсгал олон улсын байдалд маш их өөрчлөлт оруулж хятадын ард түмний эрх чөлөөний тэмцэл эрчимжихэд зохих ёсоор нөлөөлсөн билээ. Дэлхийн I дайны жилүүдэд хятадын нийгэм-эдийн засагт гарсан өөрчлөлт, пролетари болон үндэсний хөрөнгөтнүүдийн хувийн жин өссөн зэрэг нь Октябрийн социалист хувьсгал хятад оронд нөлөөлөх нөхцөл болж өгсөн.¹

Хагас колонийн хоцрогдсон Хятад оронд гадаадын империалист хүчнүүд, ялангуяа Япон улс ноёрхлоо тогтоох гэж өрсөлдөж байлаа. Японы империалистууд 1914 онд Юань Шикайн засгийн газарт «21 зүйлийн шаардлага» тулган хүлээлгээд, Германы эзэмшилд байсан Шаньдун мужид хяналтаа тогтоожээ. 1919 оны 1 сард хуралдсан Парисын энх тайвны бага хуралд Хятадын олон нийт итгэл найдвар хүлээлгэж байсан боловч уг хурлаас Шаньдун (Циндаогийн усан боомт) муж болон Хятадын талаар Германы эдэлж байсан бүх эрх мэдлийг Японд шилжүүлэхээр шийдвэрлэсэн нь зөвхөн өөрсдийн ашиг сонирхолыг зохицуулсан империалистуудын хуйвалдаан байжээ.

Парисын энх тайвны бага хурлын мэдээ даруй хятад даяар тарж, олны дургүйцэл ялангуяа оюутан залуусын хилэнг бадрааж империализмыг эсэргүүцсэн жагсаал хөдөлгөөн өрнөн гарч эхэлжээ. 1919 оны 5-р сарын 4-нд Бээжин хотын Тяньаньмэний талбайд 13 дээд дунд сургуулийн 3 мянга гаруй оюутан сурагч цуглан «21 зүйлийн шаардлагыг хүчингүй болгоё!», «Үндэстний урвагчдыг цээрлүүлье!», «Циндаог эргүүлж авъя!», «Шаньдунд эрхээ сэргээе!» гэсэн уриа лоозон барьж жагссан байна.² Уг цуглаан дээр «Парисын энх тайвны хурлаас Циндаог албан хүчээр Японд нийлүүлж, Шаньдуны бүх эрхийг авах гэж байна», «Хятадын нутаг дэвсгэрт халдаж, Хятад улсыг мохоох гэж байна», «Гадаад эрхийн төлөө, дотоодын урвагчдыг устгахын төлөө», «Хятад улсынхаа оршин тогтнолын төлөө тэмцэгтүн!»³ гэсэн агуулга бүхий «Бээжингийн оюутнуудын тунхаг бичиг»-ийг зарласан нь бүх нийтийн дэмжлэгийг шууд олсон аж. Бээжингийн эрх баригчид цэрэг цагдаагийн хүчээр жагсагчдыг хөөж тараах гэсэн боловч оюутан сурагчид улам бүр нэмэгдэж, тэмцэлд уриалсан уриа

15. Сунь Ятсен. Избранные произведения, М, 1985, с. 363

16. Сунь Ятсен, Избранные произведения М. 1985 с. 393-394

17. Ардын эрх» сонин, 1924, IV. 31. No 6

Жич: «Ардын эрх» сонины 1924 оны 7 дугаар сарын 1-ний дугаарт «Дундат иргэн улсын хувьсгалын эцэг» гэсэн гарчигтай Сунь Ятсений хувьсгалт тэмцлийн тухай өгүүлэл нийтлэгджээ. Мөн сонины 1925 оны 4 дүгээр сарын 2-ны дугаарт Сунь Ятсен нас нөгчсэн тухай Гоминьдан намын Төв хорооны мэдэгдэл, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны хариу гашуудлын цахилгааныг хэвлэжээ.

Чойжамцын Батцэцэг. Дорнодахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

лоозон хашгирч, ухуулах хуудас тарааж үргэлжлүүлэн жагссаар улам олныг хамрав, Японтой шударга бус гэрээ байгуулсан тэр үеийн Бээжингийн засгийн газрын сайд Цао Жүлиний ажлын байрыг хилэгнэсэн олон шатааж, Японд элчингээр сууж байгаад ирсэн Жан Зунсяныг барьж зоджээ. Гэвч цэрэг цагдаагийн хүчээр жагсагчдыг хөөн тарааж олон хүнийг баривчилсан учир тэдгээрийг суллахыг шаардаж 5-ны өдөр дахин жагсаал хийв. Ингээд 6-ны өдөр Бээжингийн оюутан сурагчдын нэгдсэн холбоо байгуулсан нь⁴ оюутан сурагчдын эх оронч хөдөлгөөний зохион байгуулалтад чухал зүйл болсон юм.

Бээжингийн оюутнуудын жишээгээр орон нутагт оюутан залуусын нэгдсэн холбоо байгуулан, хүн амын дунд империализмыг эсэргүүцсэн ухуулга хийж, японы бараа таваарт хориг тавих болов.⁵ Шанхай, Цзинань, Гуанжоу, Тяньжин болон бусад хотод оюутнуудыг дэмжсэн олон нийтийн ажил хаялт, жагсаал, цуглаан хийжээ.

«5-р сарын 4-ний хөдөлгөөн»-ий үзэл санаагаар 20 гаруй муж, район 100 гаруй хот сууринд ажилчдын хөдөлгөөн гарч, 1919 онд нийтдээ 90 мянга гаруй хүн ажил хаялтад оролцсон⁶ бөгөөд үүнд коммунист сэхээтнүүд манлайлах үүрэг гүйцэтгэсэн юм. Ажилчин анги бүрэлдэж, эх оронч, коммунист сэхээтэн ажилчин олон түмний холбоо зузааран бэхжиж эхэллээ.

Энэхүү хөдөлгөөн 2 сар шахам үргэлжилсний эцэст тухайн үеийн цэргийн засгийн газар олон түмний хүчинд автан арга буюу буулт хийж үндэсний зарим урвагчдыг засгийн газрын бүрэлдэхүүнээс зайлуулж хятадын ард түмний эрх ашигт харшилсан гэрээнд гарын үсэг зурахаас татгалзахад хүрсэн юм. «5-р сарын 4-ний хөдөлгөөн» нь империализмыг эсэргүүцсэн Хятадын ард түмний эх оронч ардчилсан хувьсгалт хөдөлгөөний эхлэл болж хятадын түүхэнд чухал байр эзлэх болов.

«5-р сарын 4-ний хөдөлгөөний» явцад Хятадын нэн шинэ үеийн түүхэнд асар их өөрчлөлт гарч, Хятадын ажилчин анги эхлэн анх удаа улс төрийн тэмцлийн тавцанд биеэ даасан хувьсгалт хүчин болж, улмаар энэ хөдөлгөөний үзэл санаа, ажилчин ангид тулгуурлан ХКН-ыг үндэслэн байгуулах бэлтгэл болсонд энэ хөдөлгөөний түүхэн ач холбогдол оршино. Хятадад империализмыг эсэргүүцсэн хөдөлгөөн ийнхүү өрнөсөн нь Хятадын ард түмний амьдралд шинэ үеийг нээлээ.

1919 онд өрнөсөн «5-р сарын 4-ний хөдөлгөөн»-өөс 1989 он хүртэл 70 жил өнгөрлөө. Энэ хугацаанд дэлхий дахинд тухайлан Хятадад асар их өөрчлөлт гарсан боловч 1919 оны 5-р сарын тэр нэгэн өдөр гялалзсан оч эдүгээ Хятад улсад өөрчлөн байгуулалт, шинэтгэл, үндэстний тусгаар тогтнол, ардчилал, шинжлэх ухааны ариун дөл болон бадарч байна.

Хятадын оюутан залуус нийгмийн доторхи хамгийн идэвхтэй хэсэг бөгөөд өөрчлөн байгуулалтын гол хүч бөлгөө. Одоо Хятадын залуучууд хүн амын 31,5 хувийг эзэлж, 330 саяд хүрсэн нь нийгмийн асар их нөөц хүч⁷ мөн. Хятадын бүх залуучуудын 2 сая нь оюутан, 80 сая нь ажилчин, албан хаагч, 190 сая нь тариачин, хөдөө тосгоны үйлдвэрийн газруудын 60 сая ажилчин албан хаагчдын ихэнхи хэсэг нь залуучууд байна.⁸ Гэрэлт ирээдүй болсон цог жавхланта залуучууддаа нам ард түмэн их итгэл найдвар хүлээлгэдэг. Хятад үндэстэн дэвшин мандаж, ирээдүйгээ цогцлуулах социализмын бүрэн ялалтад хүрэхэд бүх ард

түмэн, тухайлбал ахмад үеийн залгамж халаа болж үйл хэргийг нь тууштай үргэлжлүүлж тэмцэх залуу үеийнхний хүчин чармайлт маш чухал юм гэж ХКН-ЫН XIII их хурлаас тодорхойлжээ.

Хятадын өөрчлөн байгуулалт, шинэтгэлийг хэрэгжүүлэхэд залуучууд зонхилох үүрэг гүйцэтгэж байгаа хэдий ч нийгмийн хувьсал эрчимтэй явж буй өнөө үед шинэ хуучин үзлийн мөргөлдөөн хүүхэд залуучуудад нөлөөлж, тэдний үзэл санаанд зөрчилдөж байна. Нээлттэй бодлого явуулж, гадаад харилцаагаа өргөжүүлснээр үзэл суртлын элдэв урсгал дагалдан нэвтэрч янз бүрийн сөрөг үзэгдэл, зөрчилтэй тулгарах болов. Хятадын залуучууд жагсаал цуглаан хийж, хүний эрх, ардчилал болон бусад тулгамдсан асуудлыг шийдэхэд оролцдог болжээ. Сүүлийн үед гарсан томоохон хөдөлгөөн бол 1986—1987 оны зааг дээр гарсан оюутан залуусын жагсаал бөгөөд үүгээр эрх чөлөө, ардчиллыг хөгжүүлэх асуудлыг дэвшүүлсэн юм. Оюутнуудын энэхүү хөдөлгөөнийг ХКН хөрөнгөтний амьдралыг хөхүүлэн дэмжигч либерал үзлийн хандлага гээд 4 үндсэн зарчмыг баримтлах хэрэгтэйг заажээ. 4 үндсэн зарчим гэдэг нь ХКН-ын удирдлага, марксизм-ленинизм, Мао Зэдуны үзэл санаа, ардын ардчилсан диктатур, социалист зам эдгээр болно.

1982 онд шинэчилсэн Үндсэн хуульд хятадыг «Өндөр соёл, ардчилалтай социалист орон болгох» гэсэн заалтын үндсэн дээр өнгөрсөн хугацаанд боловсон хүчнийг бүх насаар нь томилон ажиллуулах системийг өөрчилж хошуу, сяний хурлыг шууд сонгуулиар явуулах өөрчлөлт хийжээ. Хятадад социалист ардчилал бүрэн төгс болж чадаагүй нь мэдээж бөгөөд тийм ч учраас өнөөгийн явуулж буй шинэчлэлт, шинэтгэл нь ардчилалыг улам боловсронгуй болгож ардчилсан улс төрийн амьдрал бүрэлдүүлж, социалист системийг сайжруулахад чиглэгдэж байгаа хэрэг юм.

«5-р сарын 4-ний» өдөр бол Хятадын залуучуудын баярын өдөр билээ. Хятадын Коммунист Залуучуудын Эвлэл одоо эгнээндээ 50 гаруй сая охид хөвгүүдийг багтааж байна. Хятадын залуучууд «5-р сарын 4-ний хөдөлгөөний» үзэл санааг шинэ түүхэн нөхцөлд улам баяжуулж, хувьсгалт уламжлалаа залгамжлах нь дамжиггүй.

1. История Китая с древнейших времен до наших дней, М., 1974, с. 256
2. Ху Хуа, «Жунго гэмин ши чжан-и» (Хятадын хувьсгалын түүхийн лекц) Бээжин хот 1980, 32 дахь тал.
3. «Жунго цзинь дай ши» (Хятадын нэн шинэ түүх) Бээжин. 1986 он, 396-397 дахь тал.
4. Мөн тэнд, 398 дахь тал.
5. ДДСА сэтгүүл, 1984 № 1, УБ., 98 дахь тал
6. ДДСА сэтгүүл. 1979, № 2, УБ, 32 дахь тал
7. «Жунго циньнянь» (Хятадын залуучууд) сэтгүүл. 1988, № 8, 23 дахь тал
8. «Ляован» сэтгүүл, 1988 № 18, 16 дахь тал,